

ХЯТАДЫН ГАДААД БОДЛОГЫН ТУХАЙ**Б. Жав**

1982 оны IX сард хуралдсан ХКН-ын XII их хурлаас БНХАУ-ын гадаад, дотоод бодлогын ойрын жилд баримтлах үндсэн чиг шугамыг заан тодорхойлсон юм. Нэг миллиард гаруй хүн амтай, 9,6 сая шахам хавтгай дөрвөлжин километр нутагтай БНХАУ-аас олон улсын тавцанд болон улс орныхоо дотоодод явуулж байгаа практик үйл ажиллагаа нь дэлхийн олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. «Азийн нэлээд районы өнөөгийн байдалд сэтгэл түгшиж байгаа БНМАУ ХКН-ын XII их хурлаас хойш хятадын эрх баригчдын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг анхааралтай ажиглан харж байна. Тэд улс төрийн гадаад ямар чиг бодлого баримталж байгаа нь бидэнд хамаарахгүй байж чадахгүй юм. Хятадын эрх баригчдын бодлого, үйл ажиллагаа нь манай оронд болон Хятадтай хөрш залгаа бүх улс гүрэнд төдийгүй нийт Ази, улмаар дэлхий дахины байдалд шууд нөлөөлж байгаа билээ»¹ гэж МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал (1982 оны XII сар) цохон тэмдэглэсэн билээ.

Улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хэвийн харилцаа тогтоон бэхжүүлэх нь олон улсын харилцааны ердийн хэм хэмжээ билээ. Гэхдээ улс хоорондын харилцаа чухам ямар чиглэл, хандлагатай хөгжин, дэлхийн энх тайвны үйлс, хүн төрөлхтний амин эрх ашигт хэр зэрэг нийцэж байгаагаар тухайн орны гадаад бодлого тодорхойлогддог юм. Чухам энэ үүднээс авч үзвэл «Мао Зэдуны үзэл санааг» урьдын адил удирдлага болгосон хятадын эрх баригчдаас 80-аад онд явуулж байгаа гадаад бодлогын үндсэн чиглэл, олон улсын харилцаанд хятадын эзэлж буй байр суурь ямар байгааг харж болно.

ХКН-ын XII их хурлаас хойш өнгөрсөн хоёр жилд хятадын гадаад бодлого, юуны өмнө дипломат үйл ажиллагаа нэлээд идэвхжлээ. БНХАУ олон улсын байгууллагын үйл ажиллагаанд зарим талаар идэвхтэй оролцох болж, нам, төр, цэрэг, эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны зэрэг олон салбарт гадаад орнуудтай харилцаагаа өргөжүүлж одоо дэлхийн 128 улстай дипломат, 100 шахам улстай худалдаа-эдийн засгийн, 130 улстай соёлын харилцаатай байна. Сүүлийн хоёр жилд Английн ерөнхий сайд М. Тэтчер, ХБНГУ-ын ерөнхийлөгч агсан К. Карстенс, Францын ерөнхийлөгч Ф. Миттеран, Японы ерөнхий сайд Я. Накасонэ, АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейган зэрэг

¹ МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал. УБ., 1982. 13—14-р тал.

гадаад орнуудын төр, засгийн тэргүүн нар хятадад айлчилж, хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян Африкийн 11 орон, Австрали, Шинэ Зеланд, АНУ болон Өрнөд европын 6 орноор, ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан Япон, ХБНСЮУ, Румын, БНАСАУ зэрэг орноор айлчиллаа. Хятадын эрх баригчид гадаад бодлогоо ийнхүү идэвхжүүлж, олон улсын нэр хүндээ дээшлүүлэх, улмаар олон улсын харилцаанд идэвхтэй нөлөөлөгч хүч болохыг эрмэлзэж байна.

ЗХУ болон социализмын бусад орны хувьд хятадын эрх баригчид «ялгаатай хандах» бодлогоо баримталсан хэвээр байна. Тэд дэлхийн социалист систем оршин тогтнож буйг үгүйсгэн², биеэ даасан хэдэн бүлэг социалист орнууд байгаа мэтээр дүрсэлж, тэдгээрийг өөр хооронд нь сөргөлдүүлэх, нэгийг нь нөгөөгийн эсрэг хандуулахад чиглэсэн чиг шугамаа баримталсаар байна. Социалист орон тус бүрд хятадын удирдлагаас өөр өөрөөр хандаж зарим орныг биеэ даасан бодлого баримтлахыг уриалж, өөртөө татах, заримд нь дарамт шахалт үзүүлэх, гүтгэн гүжирдэх зэрэг ах дүү орнуудын эв нэгдлийг сулруулах арга тактик нь эцсийн эцэст социалист хамтын нөхөрлөлийг дотроос нь задлан бутраахад чиглэж байна. Ийм нөхцөлд социалист хамтын нөхөрлөлийн орнууд Хятадтай харилцахдаа уялдуулан зохицуулсан зарчимч чиг шугамаа урьдын адил баримталж, дэлхий дахины энх тайван, бодит социализмын үйл хэрэгт дайсагнагч маоизмын онол, практикийг болон олон улсын коммунист хөдөлгөөнд ХКН-аас явуулж байгаа хагалан бутаргах үйл ажиллагааг зүй ёсоор эсэргүүцэн шүүмжилж байна.

Сүүлийн үед БНХАУ-ын удирдлага зөвлөлт, хятадын харилцааг хэвийн болгох талаар анхаарч буй байдал харуулж байгаа боловч ялангуяа тус хоёр орны улс төрийн харилцаанд баримталж байсан хуучин байр сууриа мэдэгдэхүйц өөрчлөөгүй байна. Хятадын эрх баригчид зөвлөлт, хятадын харилцааг сайжруулахад «гурван гол саадыг» арилгах, тухайлбал ЗХУ Афганистаныг «түрэмгийлж», Кампучийн эсрэг БНСВУ-ын «зэвсэгт халдлагыг» ЗХУ дэмжиж байгааг зогсоох, БНМАУ-аас зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах зүй бус шаардлагыг тавьж байна. Харин хятадын эдгээр шаардлага л зөвлөлт, хятадын харилцааг хэвийн болгоход гол саад тотгор болж байгаа билээ. Хятадын тал дээрх шаардлагыг тавьж байгаагаараа гуравдагч орны, тухайлбал БНААфГУ, БНКАУ, БНМАУ-ын дотоод хэрэгт оролцож эдгээр орны эрх ашгийг хохироох гэж байна.

Зөвлөлт, хятадын харилцааг хэвийн болгож, сайжруулах талаар ЗХУ ямагт тууштай зарчимч уян хатан байр суурь баримталсаар байгааг түүний практик үйл ажиллагаа, зөвлөлт, хятадын улс төрийн зөвлөлдөөн тодорхой харуулж байгаа билээ.

Социалист орнуудын талаар хятадын удирдлагын явуулж буй «ялгаатай хандах» бодлого нь дэлхийн социализм, энх тайвны үйлсэд илт харшилж, дайны аюулын эсрэг нийт дэвшилт хүчний тэмцлийн эгнээг сулруулахад тус дэм болж буй зүйл юм.

БНХАУ олон улсын тавцанд үйл ажиллагаагаа идэвхжүүлэхдээ империализмтэй хамтран ажиллах замаар гадаад эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэхийг гол болгож, «нээлттэй хаалгын» бодлого гэгчээ явуулж байна. «Нээлттэй хаалгын» бодлогын мөн чанар нь хэрэг дээрээ хөгжингүй хөрөнгөтөн орнуудын капиталыг хятадад өргөн нэвт-

² «Шицзе чжиши» («Дэлхийн мэдлэг»), 1983. № 11

рүүлэх, тэдгээр орноос санхүү-эдийн засгийн тусламж, орчин үеийн цэргийн технологи олж авах, нэг үгээр хэлэхэд, хятадыг 2000 он гэхэд дэлхийн хүчирхэг гүрний нэг болгох зорилго бүхий «дөрвөн шинэчлэлтийн» программыг хэрэгжүүлэхэд гол хэрэгсэл болгож байгаад оршино. Хятадын эрх баригчид «нээлттэй хаалгын» бодлогоо өөрсдийнхөө гадаад бодлогын «тулгын чулуу» гэж зарлаж байна. Гадаад эдийн засгийн харилцаагаа нэмэгдүүлэх буюу «нээлттэй хаалгын» бодлогоо өргөжүүлэх зорилтыг тэд 1984 оны V сард хуралдсан БХАТХ-ын VI дахь удаагийн сонгуулийн II чуулганаас дэвшүүлэн тавилаа. Хятадын удирдагчид ийм бодлого явуулахгүйгээр хөгжингүй хөрөнгөтөн орнуудаас эдийн засаг, техникийн талаар олон жилээр хоцорч байгаа байдлаа арилгаж чадахгүй гэдгээ илт ярих боллоо. 1978 онд анх зарласан «нээлттэй хаалгын» бодлогын хүрээнд «эдийн засгийн онцгой бүс» гэгчийг Гуандун, Фуцзянь зэрэг 4 газарт байгуулжээ. Албан ёсны мэдээгээр эдийн засгийн энэ «онцгой бүсүүд» нь гол төлөв гадаадын капиталыг ашиглаж, бүтээгдэхүүний ихэнх хэсгээ экспортод гаргах үүрэгтэй юм. Капитал оруулж буй гадаадын үйлдвэр худалдааны эзэд гааль, татварын хөнгөлөлттэй байдаг ажээ.

БНХАУ-ын Төрийн Зөвлөл энэ онд далайн эрэг орчмын Далянь, Тяньжин, Шанхай мэтийн 14 боомт хотод гадаадын хөлөг онгоц нэвтрэх эрх олгож, гаалийн татвар, түрээсгүй бүс болгох тухай шийдвэр гаргаснаа зарлалаа. Уг шийдвэрт тэмдэглэснээр гадаадтай эдийн засгийн талаар харилцах үндсэн хэлбэр нь хятадын ба гадаадын капиталын үндсэн дээр холимог үйлдвэрүүдийг байгуулах явдал мөн болохыг заажээ. 1979 оноос хойш хятадын ба гадаадын хөрөнгө оруулалтаар хятадад 105 үйлдвэрийн газар барьж ашиглалтанд оруулжээ.

«Нээлттэй хаалгын» бодлого «ашигтайг» хятадын хэвлэлд тэмдэглэн бичихдээ зөвхөн 1984 оны эхний хагаст янз бүрийн хэлбэрээр нийтдээ бараг 15 млрд. долларын өртөг бүхий гадаадын хөрөнгө оруулалтыг Хятадад оруулав гэжээ. Мөн «нээлттэй хаалгын» бодлогын талаар тус оронд «төөрөгдөл», «буруу үзэл бодол» өргөн тарж байгааг хэвлэлд шүүмжилж, одоогийн явуулж буй энэ бодлого нь империалист гүрнүүдээс Хятадад тулган хүлээлгэж байсан «нээлттэй боомт» гэгч колонийн бодлогоос «эрс ялгаатай» мэт бичиж байна. Гэтэл бодит байдал тийм биш байгаа билээ. «Нээлттэй хаалгаар» орогчид, «нээлттэй боомт»-оор нэвтрэгчид нь урьд ч, одоо ч АНУ, Япон, Англи зэрэг империалист гүрнүүд байсан, байсаар ч байгаа юм. Түүнчлэн хятадын удирдлагын одоогийн эдийн засгийн бодлого нь социализмын эсрэг үзэл санааг нэмэгдүүлэхэд хүргэж болох юм гэж тодорхой хүмүүс үзэж байгааг хятадын хэвлэл нууж чадахгүйд хүрчээ. Хятадын «Эдийн засгийн өдрийн сонин»-д («Цзинцэн жибао») «нээлттэй хаалгын» бодлого өргөжихийн хирээр хөрөнгөтний үзэл суртал, аж төрөх ёсны хорт муу төлөө тодорхой хэмжээгээр өсөх нь зайлшгүй гэж бичжээ.

Хятадын эрх баригчид «нээлттэй хаалгын» бодлогоо зөвлөлтийн эсрэг үзлийн үндсэн дээр империалист харгис хүчинтэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа зохицуулах замаар хэрэгжүүлж байна. Ийм бодлого нь империалист хүчний зүгээс энх тайван, социализм, улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг бодлого явуулахад тус дөхөм болж байна. Ийм ч учраас империалист гүрнүүд Бээжингийнхний адал балмад бодлогыг материаллаг баазтай болгох, улмаар БНХАУ-ыг улс төрийн хувьд төдийгүй эдийн засгийн талаар ч дэлхийн капиталист аж ахуйн механизмд татан оруулахыг эрмэлзэж байна. «Нээлттэй хаалгын» бодлогын өөр нэг ноцтой хор уршиг нь тус оронд

капитализмын нөлөөг нэмэгдүүлж, хөрөнгөтний үзэл суртлыг дэлгэрүүлэн, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямралыг бий болгон гүнзгийрүүлэх, улмаар БНХАУ-ыг капиталист хөгжлийн замд оруулах бодит нөхцлийг бүрдүүлж байгаа явдал юм. Ялангуяа «нээлттэй хаалгын» бодлогын хүрээнд хятад, америкийн харилцаа сүүлийн жилүүдэд улс төр, цэрэг, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын салбарт, түүнчлэн олон нийтийн болон бусад байгууллагын шугамаар алхам алхмаар өргөжиж байна. АНУ-аас Хятадад оруулж буй шууд хөрөнгө оруулалт жилд 676 сая долларт хүрч байгаа нь өөр бусад аль ч оронд оруулж байгаагаас давж байна. Зөвхөн 1983 онд АНУ-аас 170 мянга гаруй хүн янз бүрийн шугамаар Хятадад айлчилжээ. Хятадын 10 мянган оюутан, аспирант АНУ-д сурч байгаа нь 50-иад оны үед социалист орнуудад сурч байсан хятадын оюутны нийт тооноос давж байна. Хятадаас сар бүр дунджаар янз бүрийн хэмжээний 200 гаруй төлөөлөгч АНУ-д очиж байдаг болжээ.

Америкийн хэвлэлийн мэдээгээр Хятадад орчин үеийн, түүний дотор цэргийн зориулалттай технологи нийлүүлэх хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн экспортын хяналтын шинэ журмыг мөрдөж байгаа ажээ. АНУ-аас Хятадад 1982 онд 350 сая, 1983 онд 800 сая долларын өртөг бүхий орчин үеийн технологи нийлүүлсэн бөгөөд 1984 онд 1,5—2 млрд. долларт хүрнэ. Америк, Хятадын худалдааны хэмжээ 1983 онд 4,4 млрд. доллар байсан бол 1984 онд 5,5 млрд. долларт хүрч, АНУ нь Япон, Гонконгийн дараа хятадын худалдааны гуравдагч түнш болов. Хоёр орны хооронд 1979 онд 5 жилийн хугацаатай байгуулсан шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах хэлэлцээрийн үндсэн дээр 1979—1983 онд 21 гэрээ протокол байгуулж, 300 гаруй хамтарсан төслийг хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна. АНУ ийм олон тооны гэрээ хэлэлцээрийг дэлхийн өөр аль ч оронтой байгуулаагүй ажээ. АНУ-ын 800 орчим компани Хятадтай эдийн засгийн харилцаатайгаас 110 нь өөрсдийн төлөөлөгчийн газартай байна. Үүнээс гадна АНУ-ын хөрөнгө оруулалтын оролцоотойгоор баригдсан 21 холимог үйлдвэрийн газар Хятадад ажиллаж байна. Мөн хятадын 50 компани өөрийн төлөөлөгчдийн газар, салбаруудыг АНУ-д нээн ажиллуулжээ. Сүүлийн үед АНУ-аас сансрын техник, технологийг Хятадад нийлүүлэх, хятад-америкийн сансрын хамтарсан нислэг хийх асуудлыг хоёр тал ярилцаж байна. Хятад, Америкийн ийм эрчимтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд 1984 оны 1 сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян АНУ-д, АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейганы мөн оны IV сард Хятадад хийсэн айлчлал чухал үе болсон байна. Өөрөөр хэлбэл, дэлхий дахины бодлогод гарсан аюултай шинэ үзэгдэл³ болох хятад-америкийн түншлэлийн агуулга, шинж, цар хүрээ өргөжиж байгаа нь нийт хүн төрөлхтөнд, түүний дотор хятад, америкийн ард түмэнд ч нэн аюултай алхам юм.

Зэвсэг хураах, цөмийн дайны аюулыг зайлуулах зэрэг олон улсын амин чухал асуудал, Афганистан, Кампучийн талаар АНУ-ын чиг шугамтай Бээжингийн байр суурь нийлж байгаа нь хятадын удирдлагын бодлого империализмын талыг баримталсан чиглэлтэй байна. 1979 онд Дэн Сяопин АНУ-д очсоны дараа хятадын тал социалист Вьетнамын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн, одоо ч үйлдэж байгаа

³ Олон улсын байдал, ЗХУ-ын гадаад бодлогын тухай. ЗХУКН-ын Төв Хорооны бүгд хурлын тогтоол. «Үнэн», 1980.VI.25. – 152.

нь империалист харгис хүчнийхэнтэй хятадын бодлого уялдан зохицож байгааг харуулсан бодит баримт билээ.

АНУ Хятадыг Ази, Номхон далайн районд жанжлах санаархлаа хэрэгжүүлэхэд ашиглах, зөвлөлтийн эсрэг, коммунизмын эсрэг чиг шугамдаа хамруулж, империалист ашиг сонирхолдоо нийцсэн өвөрмөц эвсэл холбоог байгуулах үүднээс Хятадтай холбоотны адилаар харилцаж байна. АНУ-ын эрх баригчид сүүлийн 20 гаруй жилийн турш хятадын гадаад, дотоод бодлого дахь өөртөө ашигтай хандлагыг өөгшүүлэн дэвэргэж хоёр орны хамтын ажиллагааг эргэлт буцалтгүй болгох замаар Хятадыг эрхшээлдээ оруулахыг зорьж байна. Иймээс ч барууны талыг баримталсан хятадын бодлогыг АНУ, идэвхтэй дэмжиж, түүнийг ЗХУ болон социалист бусад оронтой харилцааг нь сайжруулахгүйн тулд зарим талаар буулт хийх, хоёр орны «стратегийн ашиг сонирхол» нэг байгаа буюу ойр байгааг цохон тэмдэглэж, цэргийн хамтын ажиллагаагаа өргөтгөн, америкийн зэр зэвсгийг Хятадад нийлүүлж, хятадыг дэлхий дахины бодлогод шадар түншээ болгохыг эрмэлзэж байна. АНУ-ын ийм бодлого нь олон улсын байдлыг эрс хурцатган, хүн төрөлхтнийг цөмийн дайнд улам ойртуулах аюултай юм. Энэ нь АНУ-аас социализмын эсрэг «загалмайтны аян дайн» хийх, ЗХУ-тай харилцаагаа хурцатгах бодлогод үйлчилж байна.

Харин хятадын удирдлага «гуравдахь ертөнцийн» орнуудад нэр хүнд, байр сууриа алдахаас болгоомжилж, АНУ-аас Ойрхи Дорнодод явуулж буй бодлогыг болон бусад зарим асуудлаар АНУ-ыг «шүүмжилж» байгаа нь зөвхөн өөрсдийнхөө ашиг сонирхлын үүднээс хийж байгаа зүйл юм.

Үүний зэрэгцээ Хятад улс социалист орнуудтай харилцаагаа сайжруулах гэсэн хандлага үзүүлж буй нь үнэн хэрэгтээ АНУ-аар буулт хийлгүүлэх, ямар нэгэн аргаар улс төрийн ашиг хонжоо олох гэсэн оролдлого юм. Ингэхдээ Хятадыг энэ зууны эцсээр дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн болгох, улмаар жанжлалаа тогтоох гэсэн стратегиа хэрэгжүүлэхийн тулд «дөрвөн шинэчлэлтийн» бодлогодоо АНУ-ын стратегийг ашиглах зорилт тавьж, империализмын хамгийн харгис хүч АНУ-тай нийгэм-улс төрийн холбоотны шинжтэй хэлхээ холбоогоо өргөтгөж байгаа нь тодорхой билээ. Эд бүхэн нь АНУ, Хятад хоёр дэлхийд жанжлах гэсэн санаархал, түүндээ хүрэхийн тулд олон улсын хурцадмал байдлыг даамжруулж, «айлган сүрдүүлэх» гэсэн оролдлого ижил буюу ойр төстэй байгааг харуулж байна.

Хятад-америкийн харилцааны эмзэг тал нь Тайваний асуудал болсон хэвээр байна. АНУ-ын империалистууд хятадын ард түмний эрх ашгийг хохироон «хоёр хятадын бодлогоо» үргэлжлүүлэн Тайвань дахь гоминьданы дэглэмд зэр зэвсгийн тусламж үзүүлсээр байна. 1984 онд 750—780 сая долларын зэвсгийн тусламжийг Тайваньд үзүүлэхээр АНУ төлөвлөжээ. АНУ Тайванийг хүчтэй зэвсэглэж, Ази, Номхон далайн бүс нутагт хяналтаа тогтооход гол түшиц газраа болгохыг оролдож байгаа юм. АНУ энэ бүс нутагт Япон, Өмнөд Солонгостой хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, цэрэг-улс төрийн томоохон бүлэглэл байгуулах гэсэн оролдлогодоо Хятадыг татан оролцуулахыг чармайж байна. Хятад улс Тайваний асуудлаар зөвхөн үндэсний явцуу эрх ашгаа урьдал болгон АНУ-тай зөрөлдөж байгаа боловч нийт хүн төрөлхтний эрх ашгийг гаргуунд нь гаргаж, АНУ-ын бодлогыг бүх талаар дэмжиж байна. Ийнхүү АНУ тэргүүтэй империалист харгис хүчнээс энх тайван, социализмын эсрэг үйлдэж буй дайсагнасан явууллагатай хятадын удирдлагын гадаад бодлого уялдан нийлж байна.

Энэ бүхнээс үзэхэд хятадын эрх баригчдаас 1980-аад онд явуулж буй гадаад бодлогын ерөнхий хандлага, үндсэн чиглэл нь империализм рүү улам бүр хэлбийж байгааг тод харуулж байна.

Хятадын гадаад бодлого нь Ази, Африкийн хөгжиж байгаа оронд нэр хүнд олж, байр суурь нөлөөгөө өргөтгөх, ялангуяа Африкийн орнуудын дунд Хятадын нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян 1982 оны сүүлч, 1983 оны эхээр Африкийн орнуудаар айлчлал хийхдээ «Бид гуравдагч ертөнцийн оронд хамаарах бөгөөд тэдний жинхэнэ холбоотон, түшиг тулгуур, найз нөхөд бол Хятад улс мөн» гэсэн сэдвийг өргөн сурталчилж байлаа. Энэ зорилгоор хөгжиж буй орнуудыг биедээ татах, тэдний дунд манлайлах байр суурь эзлэх, тэдгээр орны дотоод, гадаад бодлогод өөрсдийн үзэл бодлоо тулган хүлээлгэхийг хятадын удирдагчид эрмэлзэж байна. Хөгжиж буй орнуудтай эдийн засаг, санхүү, соёл боловсролын салбарт харилцаагаа өргөтгөж байгаа боловч хятадаас тэдгээр орны эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлэхүйц бодит тусламж үзүүлээгүй байгаа юм. Ийм байгаа мөртөө хятадын суртал нэвтрүүлэг «хэт их гүрний нөлөөнд» авталгүй байхыг тэдгээр оронд уриалж, улмаар ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас шинэ залуу хөгжиж байгаа орнуудад үзүүлж буй үлэмжийн их тусламжийн ач холбогдлыг үгүйсгэхийг оролдож байна.

Хятадын удирдлага хөгжиж байгаа орнуудын дотроос Пакистан, Тайланд, Заир, Оман зэрэг империализм, харгис хүчний талыг баримталсан орнуудтай илүү ойр дотно харилцаж, тэдгээр оронд үзүүлэх цэргийн тусламжаа нэмэгдүүлж байна. Хятадын ийм бодлого, байр суурь нь дэлхийн янз бүрийн бүс нутагт түгшүүртэй байдлыг даамжруулахад чиглэж байна.

Зэвсэглэл, цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг зогсоож, хүн төрөлхтнийг цөмийн дайны сүйрлээс аврах нь орчин үеийн гол зангилаа асуудал болж буй үед энэ асуудлаар хятадын удирдагчдын баримталж байгаа чиг шугам бол Хятад улс «шилдэг тэргүүний армитай болох», «зэвсэглэлийг хөгжүүлж сайжруулах», «Мао Зэдуны ардын дайны агуу их үзэл санааг бүх хятадын залуучууд, ард түмний дотор өргөнөөр сурталчлах»-ыг уриалж, ард түмнийхээ дотор дайнч үзэл санааг хөөргөн дэвэргэж, бусад улс үндэстнийг үзэн ядах үзлээр хүн ардаа хордуулж байгаа явдал мөн.

Улс орныг бүхэлд нь цэрэгжүүлэх чиг бодлого хэр зэрэг идэвхтэй өрнөж буйг одоо ХАЧА 4,5 сая хүнтэй, 11 мянга орчим танк, 6000 шахам нисэх онгоц, орчин үеийн байлдааны бусад техник хэрэгсэл бүхий дэлхийн хамгийн олон хүнтэй армийн нэг болоод байгаагаас харж болно. Ингэхдээ хятадын эрх баригчид эдүгээ хятадын зэвсэгт хүчний биеэ даасан төрөл болж байгаа пуужин-цөмийн потенциалыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна. Гадаадын хэвлэлийн мэдээгээр, өнөөдөр БНХАУ стратеги ба опертив тактикийн зориулалттай 20 килотонноос 4 мегатонн хүртэлх хүчин чадал бүхий 700 цөмийн цэнэгт хошуутай болжээ.

Цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс Хятад улс агаар мандалд цөмийн зэвсгийн туршилтаа үргэлжлүүлж байгаагаас гадна атомын эрчим хүчийг дан ганц цэргийн зорилгоор ашиглаж байна. Хятад улс зэвсэглэл, цөмийн зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, цөмийн зэвсэг

хэрэглэхгүй, дэлгэрүүлэхгүй байх, хориглоход чиглэсэн, тухайлбал цөмийн зэвсгийг гурван орчинд туршихыг хориглох тухай 1963 оны Москвагийн гэрээ, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай 1968 оны гэрээ зэрэг олон улсын нэг ч гэрээ, хэлэлцээрт нэгдэн ороогүйн дээр энэ талаар гарч буй бүхий л санал, санаачлагыг тасалдуулах чиг бодлого баримталж байна. Энэ нь хүн төрөлхтний соёл иргэншлийг цөмийн сүйрлээс авран хамгаалах гэсэн шударга улс түмний зүй ёсны шаардлагыг хөсөрдүүлж буй хэрэг мөн. Энэ буруу байр сууриа БНХАУ «хоёр хэт их гүрэн» цөмийн зэвсгээ 50 хувь хорогдуулахаас нааш энэ асуудлыг хөндөхгүй гэсэн зүйд үл нийцэх шаардлагаар халхавчилж байна. Хятадын эрх баригчид халуун цөмийн сүйрлээс хүн төрөлхтнийг авран хамгаалахын төлөө ЗХУ-ын явуулж буй энх тайванч гадаад бодлогыг АНУ-ын хэт харгис бүлгийнхний дайнч түрэмгий бодлоготой адилтган үзэж байна. Ингэж байгаагаараа тэд дэлхийн эсрэг тэсрэг 2 системийн хоорондын хурц ширүүн ангийн тэмцлийг үгүйсгэж, империализмын хамгийн харгис хүч, юуны өмнө АНУ-ын империализмтай хятад улсыг цэрэг зэвсгийн салбарт ойр дотно хамтран ажиллах болгожээ.

Хятадыг хүчирхэг милитарист гүрэн болгох Маогийн санаархлыг Хятадын эрх баригчид залгамжлан идэвхтэй үргэлжүүлж байгаа өнөөгийн нөхцөлд тус орны улс төр, нийгэм-эдийн засгийн амьдралд армийн нөлөө хүчтэй хэвээр байна. БНХАУ зэвсгийн хүч чадал, цэргийн зардлаа нэмэгдүүлэн, зэвсэг хураахад оролцохгүй байгаа нь империалист харгис хүчний түрэмгий санаархалд нийцэж байна. Нөгөөтэйгүүр, улс орноо цэрэгжүүлэн зэвсэглэх бодлогыг хэрэгжүүлэхдээ хятадын эрх баригчид АНУ, Япон болон бусад империалист орноос ихээхэн хэмжээний зэр зэвсэг, санхүүгийн тусламж авах гэж оролдож байна.

Бээжингийн гадаад бодлогын чиг шугам ийнхүү энх тайван, социализмын үйлсэд хортой хэвээр байна. Хэрэг дээрээ Хятадыг империалист түрэмгий хүчнийхний хань хамсаатан болгосон энэ чиг шугам нь бас хятадын ард түмний язгуур эрх ашиг, тус орон дахь социализмын үндсийг эвдэн бусниулахад их хор хохирол учруулсан хэвээр байна.

О ВНЕШНЕЙ ПОЛИТИКЕ КНР

(Р е з ю м е)

Автор в статье подчеркивает основные тенденции и важные моменты внешнеполитической деятельности китайского руководства после XII съезда КПК и приходит к выводу, что во внешней политике пекинские лидеры фактически по-прежнему придерживаются «идей Мао-цзэдуна» и проводят политику смыкания с агрессивными кругами империалистической реакции.

Активизация внешнеполитической, особенно дипломатической, деятельности КНР на международной арене связана с усилиями правящих кругов Китая к восстановлению серьезно подорванного «культурной революцией» авторитета КНР на мировой арене, а также к

превращению Китая во влиятельную» силу в международных отношениях.

Автор статьи отмечает, что, хотя во внешней политике КНР в последние годы наблюдаются некоторые тенденции к улучшению отношений КНР с Советским Союзом и другими странами социалистического содружества во второстепенных областях (торгово-экономические, культурные и др. связи), проводимая ею по отношению к ним «дифференцированная политика» не приводит к существенному улучшению её отношений со странами мирового социализма в целом.

Правящие круги Китая, смыкаясь с силами империалистической реакции, проводят политику «открытых дверей» в своих внешне-экономических связях с развитыми капиталистическими странами, а в отношениях с развивающимися государствами «третьего мира»-политику противопоставления их странам социалистического содружества .

В заключении статьи автор делает вывод о том, что в последние годы внешнеполитический курс китайского руководства после XII съезда КПК в основном характеризуется антисоциалистическим на правлением в важнейших вопросах войны и мира, разоружения и устранения угрозы ядерного конфликта, подчиненным только целям осуществления его великодержавных гегемонистских устремлений на международной арене.